



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/86/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70273465 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/133
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн захиргааны мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж, стандартын биелэлтийг ханган, олон талт мэдээлэл арга зүйгээр үйлчилж, төрийн ажил үйлчилгээг иргэдэд ил тод, шуурхай хүргэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	74,800,220.01	81,536,270.00
33	АВЛАГА	92,110.01	0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	76,801.01	0
33500	Бусад авлага	15,309.00	0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	15,309.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	74,708,110.00	81,536,270.00
35400	Хангамжийн материал	74,708,110.00	76,536,270.00
35410	Бичиг хэргийн материал	623,000.00	330,000.00
35420	Аж ахуйн материал	4,951,629.00	1,886,330.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	663,100.00
35450	Барилгын засварын материал	2,049,000.00	2,049,000.00
35470	Бусад хангамжийн материал	67,084,481.00	71,607,840.00
35600	Мал амьтад	0	5,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,860,523,002.42	2,113,913,870.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,860,523,002.42	2,113,913,870.10
39200	Биет хөрөнгө	1,434,066,169.34	1,687,499,537.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,213,265,142.00	1,270,470,342.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-96,347,654.94	-134,043,294.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	169,594,800.00	225,903,890.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,233,319.43	-112,655,911.03
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	88,934,010.00	223,653,736.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,485,809.09	-55,581,196.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,295,434.00	71,635,434.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,174,195.75	-31,279,532.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	328,115,086.00	440,095,086.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-196,897,323.45	-210,699,017.21
39300	Биет бус хөрөнгө	426,456,833.08	426,414,333.04
39301	Програм хангамж	340,000.00	340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-269,166.92	-311,666.96
39303	Бусад биет бус хөрөнгө	426,386,000.00	426,386,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,935,323,222.43	2,195,450,140.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,935,323,222.43	2,195,450,140.10
51	Засгийн газрын хувь оролцоо	1,935,323,222.43	2,195,450,140.10
51100	Засгийн газрын оруулсан капитал	710,837,936.62	710,837,936.62
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	710,837,936.62	710,837,936.62
51200	Хуримтлагдсан үр дүн	909,325,189.56	1,169,452,107.23
51210	Өмнөх үеийн үр дүн	910,140,773.56	909,325,189.56
51220	Тайлант үеийн үр дүн	-815,584.00	260,126,917.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	315,160,096.25	315,160,096.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,935,323,222.43	2,195,450,140.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	660,704,630.00	823,753,044.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,361,826.00	348,522,127.10
120	Нийтлэг татварын бус орлого	112,361,826.00	348,522,127.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	154,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	154,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	110,176,326.00	343,368,127.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,185,500.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	548,342,804.00	475,230,917.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,508,404.00	30,352,817.06
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,809,000.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	388,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,708,404.00	11,586,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,991,000.00	13,377,448.06
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	467,834,400.00	444,878,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	467,834,400.00	444,878,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	634,576,200.20	563,525,015.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,576,200.20	544,025,015.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	560,496,578.65	523,410,497.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,209,735.86	237,430,717.46
210101	Үндсэн цалин	185,619,003.02	171,092,032.56
210102	Нэмэгдэл	16,410,611.57	24,872,756.86
210104	Урамшуулал	0	9,680,933.04
210105	Гэрээт ажлын хөлс	33,180,121.27	31,784,995.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,003,209.00	28,585,628.67
210201	Тэтгэврийн даатгал	21,164,551.91	20,115,980.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,368,777.39	2,381,438.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,888,302.49	1,905,150.17
210204	Ажилгүйдлийн даатгал	416,507.53	371,754.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,165,069.68	3,811,304.20

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,094,496.96	72,592,618.91
210301	Гэрэл, цахилгаан	5,370,072.96	5,514,973.91
210302	Түлш, халаалт	62,559,024.00	62,627,400.00
210303	Цэвэр, бохир ус	7,165,400.00	4,450,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,340,368.63	34,387,979.00
210401	Бичиг хэрэг	4,476,544.00	3,769,600.00
210402	Тээвэр, шатахуун	29,455,730.00	21,303,944.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	930,329.63	1,030,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	833,400.00	3,761,006.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,683,150.00	4,523,429.00
210408	Бараа материал акталсны зардал	6,961,215.00	0
2105	Нормативт зардал	3,660,650.00	450,000.00
210502	Хоол, хүнс	3,263,650.00	450,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	397,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,462,000.00	3,890,170.00
210604	Урсгал засвар	3,462,000.00	3,890,170.00
2107	Томилолт, зочны зардал	2,701,400.00	3,565,200.00
210702	Дотоод албан томилолт	2,701,400.00	3,565,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,864,841.00	1,668,528.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	353,341.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	756,700.00	697,936.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	365,792.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,159,877.20	140,839,655.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,692,460.00	37,676,507.06
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,467,417.20	103,163,148.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,079,621.55	20,614,517.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,734,400.00	2,403,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,734,400.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	2,403,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,345,221.55	18,211,517.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,345,221.55	18,211,517.97
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	19,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	19,500,000.00
223001	Хаагдсан данс	0	19,500,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	26,128,429.80	260,228,028.77
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,682,500.00	0
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	4,682,500.00	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,626,513.80	101,111.10
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	31,626,513.80	101,111.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-815,584.00	260,126,917.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	562,518,804.00	475,477,027.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	92,110.01
120	Нийтлэг татварын бус орлого	0	92,110.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	92,110.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	92,110.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	562,518,804.00	475,384,917.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,684,404.00	30,506,817.06
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,809,000.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	388,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,708,404.00	11,586,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,167,000.00	13,531,448.06
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	467,834,400.00	444,878,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	467,834,400.00	444,878,100.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	561,990,978.00	442,690,027.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,990,978.00	442,690,027.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	486,911,356.45	421,478,509.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,513,408.90	205,277,793.87
210101	Үндсэн цалин	186,007,349.04	167,635,128.40
210102	Нэмэгдэл	15,675,302.82	27,961,732.43
210104	Урамшуулал	0	9,680,933.04
210105	Гэрээт ажлын хөлс	34,830,757.04	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,699,535.96	24,936,810.67
210201	Тэтгэврийн даатгал	19,860,879.40	17,593,036.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,368,776.88	2,063,592.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,888,301.57	1,650,874.17
210204	Ажилгүйдлийн даатгал	416,507.07	321,408.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,165,071.04	3,307,898.20

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,094,496.96	72,592,618.91
210301	Гэрэл, цахилгаан	5,370,072.96	5,514,973.91
210302	Түлш, халаалт	62,559,024.00	62,627,400.00
210303	Цэвэр, бохир ус	7,165,400.00	4,450,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,533,999.63	28,320,055.00
210401	Бичиг хэрэг	4,088,400.00	3,274,600.00
210402	Тээвэр, шатахуун	28,648,470.00	18,878,755.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	930,329.63	1,030,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	5,041,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,866,800.00	95,000.00
2105	Нормативт зардал	3,699,000.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	2,899,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,486,000.00	3,460,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000.00	0
210604	Урсгал засвар	4,484,000.00	3,460,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,701,400.00	3,565,200.00
210702	Дотоод албан томилолт	2,701,400.00	3,565,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,143,841.00	42,404,413.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	632,341.00	40,735,885.59
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	756,700.00	697,936.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	365,792.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,039,674.00	39,921,617.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,883,674.00	39,921,617.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	156,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,079,621.55	21,211,517.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,734,400.00	3,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,734,400.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	3,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,345,221.55	18,211,517.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,345,221.55	18,211,517.97
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	527,826.00	32,787,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	528,000.00	32,787,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	528,000.00	32,787,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	528,000.00	32,787,000.00
222001	Тоног төхөөрөмж	0	12,550,000.00
223001	Бусад хөрөнгө	0	19,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	528,000.00	737,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-528,000.00	-32,787,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-174	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	174	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	710,837,936.62	374,463,987.42	850,836,891.30	1,936,138,815.34
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	59,303,882.26	59,303,882.26
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	710,837,936.62	374,463,987.42	910,140,773.56	1,995,442,697.60
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-59,303,891.17	0	-59,303,891.17
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-815,584.00	-815,584.00
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	710,837,936.62	315,160,096.25	909,325,189.56	1,935,323,222.43
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	710,837,936.62	315,160,096.25	909,325,189.56	1,935,323,222.43
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	710,837,936.62	315,160,096.25	909,325,189.56	1,935,323,222.43
19	Тайлант үеийн үр дүн	0	0	260,126,917.67	260,126,917.67
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	710,837,936.62	315,160,096.25	1,169,452,107.23	2,195,450,140.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	458,897,800.00	426,021,692.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	426,797,800.00	394,708,692.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	423,797,800.00	391,708,692.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,401,500.00	205,277,793.87
210101	Үндсэн цалин	177,743,400.00	167,635,128.40
210102	Нэмэгдэл	49,658,100.00	27,961,732.43
210104	Урамшуулал	0	9,680,933.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,699,300.00	24,936,810.67
210201	Тэтгэврийн даатгал	21,603,200.00	17,593,036.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,274,000.00	2,063,592.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,819,200.00	1,650,874.17
210204	Ажилгүйдлийн даатгал	454,900.00	321,408.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,548,000.00	3,307,898.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,526,400.00	68,368,373.91
210301	Гэрэл, цахилгаан	6,673,000.00	5,514,973.91
210302	Түлш, халаалт	62,627,400.00	62,627,400.00
210303	Цэвэр, бохир ус	226,000.00	226,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,237,600.00	24,237,600.00
210401	Бичиг хэрэг	3,130,600.00	3,130,600.00
210402	Тээвэр, шатахуун	14,577,000.00	15,035,300.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,030,000.00	1,030,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,500,000.00	5,041,700.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,460,000.00	3,460,000.00
210604	Урсгал засвар	3,460,000.00	3,460,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,565,200.00	3,565,200.00
210702	Дотоод албан томилолт	3,565,200.00	3,565,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,449,300.00	37,404,413.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,117,800.00	35,735,885.59
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	756,700.00	697,936.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	970,000.00	365,792.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,458,500.00	23,458,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,458,500.00	23,458,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	3,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	3,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,100,000.00	31,313,000.00
222001	Тоног төхөөрөмж	12,600,000.00	12,550,000.00
223001	Бусад хөрөнгө	19,500,000.00	18,763,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	458,897,800.00	444,970,210.01
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	422,297,800.00	444,878,100.00
320001	Орон нутгийн төсвөөс	422,297,800.00	444,878,100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	36,600,000.00	92,110.01
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	92,110.01
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	36,600,000.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	30,506,817.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	30,506,817.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	30,506,817.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	4,224,245.00
210303	Цэвэр, бохир ус	-	4,224,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	4,082,455.00
210401	Бичиг хэрэг	-	144,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,843,455.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	95,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	5,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	17,200,117.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	17,200,117.06
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	30,352,817.06
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	30,352,817.06
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	388,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	11,586,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	13,377,448.06

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, төрийн захиргааны мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж, стандартын биелэлтийг ханган, олон талт мэдээлэл арга зүйгээр үйлчилж, төрийн ажил үйлчилгээг иргэдэд ил тод, шуурхай хүргэхэд оролцох чиг үүрэг бүхий Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 43 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталснаас хэрэгжилт 91,6%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Засаг даргын Тамгын газрын дарга 1, удирдах 7, гүйцэтгэх 12, гэрээт ажилтан 6 бүгд 26 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай" А/03 тушаал, 5 хүний бүрэлдэхүүнтэй, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг мөрдөж ажиллаж байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын хэсэг нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 5 хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын баг нь жилийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт санхүүгийн үйл ажиллагаанд хийж, алдаа зөрчил гарвал тухай бүрд нь засаж залруулах зөвлөмж өгч эргэн хяналт тавьж ажилладаг. Энэ онд шилэн дансанд хяналт шалгалт хийсэн байна.

Тус байгууллагад тайлант онд Төв аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2022 оны 6 дугаар сард 2020 болон 2021 оны санхүүгийн тайлангийн баримтад хяналт шалгалт хийсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2013 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь 4 бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна. НББ-ийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 260,126.9 мянган төгрөгөөр буюу 13,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		Өөрчлөлт
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	74,708.1	81,536.3	6,828.2
Үндсэн хөрөнгө	1,860,523.0	2,113,913.9	253,390.9
Нийт хөрөнгө	1,935,323.2	2,195,450.1	260,126.9
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,935,323.2	2,195,450.1	260,126.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,935,323.2	2,195,450.1	260,126.9

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гараагүй. Үндсэн хөрөнгийн дансанд орлого зарлагын хөдөлгөөн хийгдсэн болон хөрөнгийн элэгдлийн зардлаас

шалтгаалан өмнөх оны үзүүлэлтээс 253,390.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,195,450.1 мянган төгрөг болж 260,126.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 445,675.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 34,143.2 мянган төгрөгөөр бууруулж Төв аймгийн Цээл сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 08 дугаар албан бичгийн хавсралтаар 2022 оны урсгал зардлын төсвийг 411,531.8 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Тайлант хугацаанд төсөвт 1 удаагийн тодотгол хийгдэж 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор 15,265.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 426,797.7 мянган төгрөгөөр ирүүлсэн байна. Энэ нь урсгал зардлын хэмжээг 15,265.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 2 /орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага/ хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 426,797.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 18,211.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 408,586.2 мянган төгрөг буюу 95,7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 18,211.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101 үндсэн үйл ажиллагааны зардал	289,428.4	266,023.8	23,404.6	91,9
2	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103 гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	46,609.7	44,175.4	2,434.3	94,8
3	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106 баг хорооны үйл ажиллагааны зардал	66,317.2	64,474.9	1,842.3	97,2
4	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	1,000.0	1,000.0	0	100,0

5	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80918 бусад	32,100.0	32,050.0	50.0	99,8
6	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102 орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0	100,0
7	70106 орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801 улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100,0
8	71411 хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 81701 байгаль орчныг хамгаалах	3,442.5	3,442.5	0	100,0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 11,586.6 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаас 5,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 388.8 мянган төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 13,377.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 154.0 мянган төгрөг нийт 30,506.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гэрэл цахилгаан, түлш, халаалтад 4,224.2 мянган төгрөг, бичиг хэрэг, тээвэр шатахуунд 4,082.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 5,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 17,200.1 мянган төгрөг нийт 30,506.8 мянган төгрөг зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хөтөлбөр 95,7 %	426,797.7	408,586.2

2	71411	2022.01.01- 2022.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	Хөтөлбөр 100%	3,442.5	3,442.5
---	-------	---------------------------	---	------------------	---------	---------

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар нийт 18,211.5 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн 04/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн ИТХ-ын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан 2022 оны нийт зарлага 448,847.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,732.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,049.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4

орлогын, 22 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 52 гүйлгээний 10 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн 04/107 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	33,506.3	1	33,506.3	100
Зөвлөмж	2	92.1	2	92.1	100
Нийт дүн	3	33,598.4	3	33,598.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 154.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 154.0 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1.Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлогын 154.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжих орлогод тусгаж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 7,431.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 7,431.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жижиг мөнгөн сангийн журмаар бараа ажил үйлчилгээнд 300.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 500.0 мянган төгрөг авах эрхтэйгээс тус байгууллага баяр наадмын зардалд 1,078.5 мянган төгрөгийн бэлэн мөнгөн авсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид бэлэн мөнгөний хэмжээг хэтрүүлэхгүй байх.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шатахууны 6,352.8 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаж байх.

3. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 2022 онд байршуулах мэдээлбэл зохих 171 мэдээллээс хугацаа хоцроосон 59 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, тухай бүр мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

